



БАЯНХОНГОР АЙМГИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛИЙН НОМУНДАЛАЙ СУРГУУЛИЙН ОЮУНЫ ӨМЧИЙН БОДЛОГО

1. Зорилго

Энэхүү бодлогын зорилго нь Баянхонгор аймгийн ерөнхий боловсролын Номундалай сургуулийн багш, ажилтан, суралцагчдийн бүтээсэн оюуны өмчийг тодорхойлох, хамгаалах, ашиглах болон эзэмшихтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

2. Хамрах хүрээ

Энэхүү бодлого нь сургуулийн нийт багш, ажилтан, суралцагчид болон сургуулийн нөөц бололцоог ашиглан оюуны бүтээл туурвиж буй гэрээт этгээдүүдэд нэгэн адил хамаарна.

3. Оюуны өмчийн өмчлөл

3.1 Сургуулийн орчинд үүсэх оюуны өмчийг дараах байдлаар ангилна. Үүнд:

- **Байгууллагын өмч:** Сургуулиас өгсөн үндсэн ажлын даалгавар, төлөвлөгөө, санхүүжилтийн хүрээнд бүтээсэн бүтээлүүд (сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, presentation, эрдмийн ажил, судлагааны ажил, ном, сурах бичиг, оюуны бүтээл, сургуулийн лого, дуу, дүрс, сургалтын хэрэглэгдэхүүн гэх мэт)
- **Хамтарсан өмч:** Сургуулийн нөөцийг ашиглан бүтээсэн инновацын бүтээл, шинэ бүтээл, ашигтай загвар (эзэмших хувийг тусгайлсан гэрээгээр зохицуулна.)
- **Хувь хүний өмч:** Сургуулийн нөөцийг ашиглаагүй, ажлын цагаас гадуур туурвисан уран зохиол, урлагийн бүтээл болон сургуультай холбоогүй судалгааны ажил

4. Оюуны өмчийг хамгаалах үйл ажиллагаа

4.1 Сургууль нь дараах арга хэлбэрээр оюуны өмчийг хамгаална. Үүнд:

- **Бүртгэлжүүлэлт:** Сургуулийн дотоод "Оюуны өмчийн сан"-г бүрдүүлж, бүтээл бүрийг коджуулан бүртгэнэ.
- **Тэмдэг ба зохиогчийн эрх:** Бүх цахим болон хэвлэмэл гарын авлага дээр © тэмдэг болон сургуулийн нэр буюу логог байршуулна.

5. Бусдын оюуны өмчийг хүндэтгэх (Эш татах)

- Сургалтын үйл ажиллагаанд ашиглаж буй гадны бүх эх сурвалж (ном, зураг, видео, программ) нь албан ёсны зөвшөөрөлтэй эсвэл нээлттэй эх сурвалж байна.
- Багш, ажилтан, сурагчид эш татах соёлыг чанд баримтална. Хэрвээ хэн нэгний оюуны өмчийг ашиглахаар бол эх сурвалжийг заавал дурддаг байх.

6. Урамшуулал ба ашиглалт

- Сургууль нь багш, ажилтан, сурагчдын бүтээсэн оюуны өмч (хамтарсан болон хувь хүний өмч)-ийг зах зээлд нэвтрүүлэх, арилжаалах замаар орлого олохыг дэмжих бөгөөд ашгийн тодорхой хувийг бүтээгчид олгоно.
- Шилдэг инновац, шинэ техник технологийн шийдэл гаргасан багш, ажилтан, сурагчийн Оюуны өмчийн газарт патент авах зардлыг сургуулиас хариуцаж болно.